



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ОРХОН АЙМАГ
ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР	7
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР	16
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР	19
АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРСДИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТЫН ТАЛААР	23
СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ	26
ДОТООД АЖЛЫН ТАЛААР	29
ШИНЭЭР САНААЧИЛСАН АЖИЛ	33
ДҮГНЭЛТ, САНАЛ	35



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУЕА- Монгол улсын Ерөнхий аудитор

СТАУС- Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем

ҮАГ- Үндэсний аудитын газар

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

АИТХ- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ХББЗА– Хот байгуулалт барилга захиалагчийн алба

БОЭТ- Бүсийн оношилгоо, эмчилгээний төв

ТББ – Төрийн бус байгууллага

АТГ – Авлигатай тэмцэх газар

ОНӨААТҮГ- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

ТБОНӨААН- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

ТЕЗ- Төсвийн ерөнхийлөн захирагч

АДБОУС- Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

ӨЭМТ- Өрхийн эрүүл мэндийн төв



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно,” гэж, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Монгол улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.” гэж Төрийн аудитын байгууллага Үндсэн хуулийн байгууллага болж, Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга Монгол улсын Их хурлаар батлагдсанаар, 2020 онд ТАБ-ын хэмжээнд Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчины шинэтгэлийн жил болох зорилт бүрэн хангагдсан жил болж өнгөрлөө.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь Шинэчлэн батлагдсан хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон дэвшүүлсэн зорилт, жилийн үйл ажиллагааны болон аудитын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

1-Р БҮЛЭГ

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнөөс гаргасан ТАБ-ын хэмжээнд “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгох зорилт дэвшүүлснийг удирдлага болгон, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 бүлэг 62 арга хэмжээ, өмнөө тавьсан зорилтоо бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу санхүүгийн аудитын албанд 5, гүйцэтгэлийн аудитын албанд 2, нийцлийн аудитын албанд 2 хүний бүрэлдэхүүнтэй, 3 багийн зохион байгуулалтад оруулан, аудитын төлөвлөгөөнд үндэслэн аудитыг хуваарилан, ажлын ачаалал жигд тэнцвэртэй байх бодлого барин ажилласнаар ажлын чанарт эерэг нөлөө үзүүлж, төлөвлөгөөт аудит, YAГ-аас ирсэн үүрэг даалгавруудыг цаг хугацаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Дотоод удирдлагын Эйбл системийн тусламжтайгаар ТАБ-ын хэмжээнд мэдээллийг шуурхай хүлээн авч, харилцан солилцон, YAГ-аас ирүүлсэн чиглэл, зааварчилгаа, санал асуулгыг шуурхай дамжуулж, Zoom, Teams зэрэг цахим системийг өргөн нэвтрүүлсэн жил байлаа.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 129 байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн бол, гүйцэтгэлийн 7, нийцлийн 5 аудитыг төлөвлөгөөнд заасан хугацаанд хийж, тайлан мэдээг хүргүүлэн ажиллаа. МУЕА-н А/20 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу байгууллагын албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангасан. Төрийн жинхэнэ албан хаагчдаас 2020 оны гүйцэтгэлийн тайлан, биелэлтийг гаргуулан, байгууллагын гүйцэтгэлийн тайланг улирал бүр гарган YAГ-т тайлагнасан.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх, санхүүгийн аудитын бодлого, арга зүйг төлөвшүүлэх, боловсронгуй болгох зорилтын хүрээнд 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг 2020 оны А/11 дүгээр тушаалаар томилон, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. Албан даалгаврын нэгдүгээр заалтын хүрээнд СТАУС программын "Мэдээллийн сан" цэсний "Үйлчлүүлэгч байгууллага" хэсэгт 2020 оны санхүүгийн тайланд хамрагдах 129 байгууллагын мэдээллийг шинэчлэн, 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх 129 байгууллагын жагсаалтыг санхүүгийн тайланд аудит хийх журмын 10.5-д заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгаж, А20101 маягтаар гарган (PDF хэлбэрт шилжүүлэн) Стратеги удирдлагын газар хүргүүлж, МУЕА-н А/64 дугаар тушаалаар батлагдсан. 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

байгууллагуудын хуваарийг гарган баталгаажуулж, СТАУС программд оруулан аудитын төлөвлөлтийн үе шатны ажил хийгдэх бэлтгэл ажил хангагдан, завсрын аудит хийгдэж байна.

ҮАГ-н Гүйцэтгэл, Нийцэл, Санхүү, Стратеги удирдлагын газрууд болон Тамгын газар, Ажлын албанаас албан бичгээр ирүүлсэн хугацаатай болон хугацаагүй бичиг, үүрэг чиглэл, шаардлагатай тайлан, мэдээ, судалгаа, саналыг тухай бүрд нь хүргүүлэн хамтран ажиллаа.


Тайлант хугацаанд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ, хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байх үндсэн зарчмуудыг баримтлан, ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж ажиллаа.

Иргэдийн санал бодлыг шинжлэх ухааны үндэстэй судалгааны дүнд тулгуурлан тодорхойлж, үйл ажиллагааны богино болон урт хугацааны төлөвлөгөө, чиглэл, зорилгодоо тусгах зорилго бүхий судалгааны ажлын гэрээг ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академитай байгуулсан. Судалгааны зорилго, зорилтууд, хүлээгдэж буй үр дүн, судалгааны арга зүй, хамрах хүрээг тодорхойлсон төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөө, удирдамжийн дагуу Орхон аймгийн 26 багын 458 өрхөөс судалгааг авч, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө иргэдийн санал бодлыг тусгах, цаашид үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд таниулах, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах 5 зөвлөмж, 7 дүгнэлт бүхий Судалгааны тайланг баталгаажуулан, хүлээн авсан.

Төрийн аудитын байгууллагын аудитаар хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд онцгой анхаарч, аудит хийгдсэн байгууллага бүрд очиж ажиллан, хэрэгжилтийг нотлох баримтаар тулган баталгаажуулж, үр дүнг тооцон ажиллаа. Нотлох баримтад ач холбогдол өгч, аудитад авагдсан нотлох баримтын шаардлагыг хангуулж, тухай бүр тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажуулан аудитын баримтад хавсаргаж ажиллаа.

2020 ОНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ:

Зөвлөмж: 2020 оны эхэнд 6276.4 сая төгрөгийн 54 зөвлөмжийн үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 5475.0 сая төгрөгийн 298 зөвлөмж хүргүүлж, нийт 11751.4 сая төгрөгийн 352 зөвлөмж бүртгэгдэн, өмнөх оны 6276.40 сая төгрөгийн 44, энэ оны 2422.05 сая төгрөгийн 260 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан, 3052.9 сая төгрөгийн 48 зөвлөмжөөс, 1722.5 сая төгрөгийн 24 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1330.4 сая төгрөгийн 24 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.






2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлбөрийн акт: 2020 оны эхэнд 374.4 сая төгрөгийн 28 актын үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 198.4 сая төгрөгийн 68 акт нэмж бүртгэгдэн, нийт 572.8 сая төгрөгийн 96 актаас, өмнөх оны 4 актын 2.0 сая төгрөг, энэ оны 62.9 сая төгрөгийн 62 актын биелэлтийг хангуулан, орон нутгийн төсөвт 64.9 сая сая төгрөгийг төвлөрүүлэн, 354.9 сая төгрөгийн 9 актын үлдэгдэлтэйгээс 118.6 сая төгрөгийн 2 акт хэрэгжих шатандаа 236.3 сая төгрөгийн 7 акт хугацаа хэтэрсэн байна.


Тайлант хугацаанд төлбөрийн актын 90.6 хувь, үнийн дүнгийн 79.2 хувийг биелүүлсэн байна.



Албан шаардлага: 2020 оны эхэнд 623.7 сая төгрөгийн 12 албан шаардлагын үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 5408.6 сая төгрөгийн 78 албан шаардлага нэмж бүртгэгдэн, нийт 6032.3 сая төгрөгийн 90 албан шаардлагаас, өмнөх оны 9 албан шаардлагын 619.4 сая төгрөг, энэ оны 1369.1 сая төгрөгийн 65 албан шаардлагын биелэлтийг хангуулан, 4041.9 сая төгрөгийн 16 албан шаардлагын үлдэгдэлтэй ажиллаа. Үүнээс 2915.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хэрэгжих шатандаа, 1126.1 сая төгрөгийн 14 албан шаардлага хугацаа хэтэрсэн байна.




2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Үр өгөөж: 2018 онд нийт үр өгөөжийн тоо 150, үүнээс 102 буюу 3846.9 сая төгрөг нь санхүүгийн үр өгөөж, 48 нь санхүүгийн бус үр өгөөж, 2019 онд тооцоолсон нийт үр өгөөжийн тоо 150 байгаагаас 83 буюу 10509.4 сая төгрөг нь санхүүгийн үр өгөөж, 67 нь санхүүгийн бус үр өгөөж байсан бол тайлант онд тооцоолсон нийт үр өгөөжийн тоо 121 байгаагаас 93 буюу 14724.3 сая төгрөг нь санхүүгийн үр өгөөж, 28 нь санхүүгийн бус үр өгөөж байна. 2018 оноос үр өгөөж 10877.4 сая төгрөгөөр, 2019 оноос 4214.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

2018 онд 250.1 сая төгрөгийн төсвийг зарцуулж төсвийн 1 төгрөгт 15.3 төгрөгийн аудитын үр өгөөжтэй, 2019 онд 275.1 сая төгрөгийн төсвийг зарцуулж, төсвийн 1 төгрөгт 38.20 төгрөгийн аудитын үр өгөөжтэй ажиллаж байсан бол тайлант онд 426.4 сая төгрөгийн төсөв зарцуулж төсвийн нэг төгрөгт 34.5 төгрөгийн үр өгөөжтэй ажиллаа.

Өмнөх оноос үр өгөөжийн дүн 4214.9 сая төгрөгөөр нэмэгдсэн хэдийн ч 1 төгрөгт ногдох үр өгөөж 3 төгрөг 70 мөнгөөр буурсан нь байгууллагын төсөв өмнөх оноос 151.3 сая төгрөг буюу 45 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.



Дээрх статистик мэдээний дүнгээс үзэхэд зөвлөмжийн 86.6 хувийг, төлбөрийн актын 90.6 хувийг, албан шаардлагын 82.2 хувийг тус тус хэрэгжүүлсэн дүнтэй байна.

2-Р БҮЛЭГ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР



2.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2.1.1 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8-р зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 18-р зүйлд заасны дагуу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаж ирүүлсэн 129 байгууллагын санхүүгийн тайланд, санхүүгийн тайлангийн аудит хийх журмыг хэрэгжүүлэн, аудитад СТАУС программ ашиглан, ахлах аудитор 1, аудитор 4, гэрээт 2 ажилтан, 2 хувийн аудитын компаниар аудит гүйцэтгэн, аудитын менежер, тэргүүлэх аудитор нар үе шатны хяналтын ажлыг хэрэгжүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитад давхардсан тоогоор 23 хүн 702 өдөр зарцуулан, 1120 цаг илүү цагаар ажилласан байна

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад 126 байгууллага хамрагдахаас 13 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 11 байгууллагын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 102-н байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргахаас, 78.4 хувийг төрийн аудитын байгууллага, үлдсэн 21.6 хувийг хувийн хэвшлийн хараат бус аудитын компаниар гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 13 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 14 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 102-н байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган нийт 129 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаал гарснаас хойш буюу 2019 оны 7-р, 9-р сард шинээр байгуулагдсан "Мэдээлэл шуурхай удирдлагын төв", "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа"-ны санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хүсэлт ҮАГ-т хүргүүлэн гүйцэтгэсэн. МУЕА-ын орлогчийн өгсөн чиглэлд дурдсаны дагуу Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж гүйцэтгэлээ.

"Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам"-ын дагуу 13-н байгууллагад итгэл үзүүлсэн нь аудитад хамрагдсан санхүүгийн тайлангийн 10.0 хувь, 14 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн нь аудитад хамрагдсан санхүүгийн тайлангийн 10.8 хувийг тус тус эзэлж байна.

Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлогдсон чиг үүргийнхээ дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын болон улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, өрхийн эмнэлгийн 102 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасны 78.5 хувийг төрийн аудитын байгууллага, үлдсэн 21.5 хувийг хувийн хэвшлийн хараат бус аудитын компаниар гэрээгээр гүйцэтгүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 2, төсөл сан 4, төсвийн шууд захирагч 60, орон нутгийн өмчит компани 5, өрхийн эмнэлэг 8, нийт 80-н байгууллага, Далайван Аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбар, Мэжик консалтинг аудит ХХК-ийн Орхон салбар хараат бус аудитын компаниар төсвийн шууд захирагч 20 байгууллага, орон нутгийн 2 байгууллага нийт 22 байгууллагад аудит хийж дүгнэлт гарган ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт гаргасан 102 байгууллагаас 95 байгууллага буюу 93.2 хувьд зөрчилгүй, 7 байгууллага буюу 6.8 хувьд хязгаарлалтай **ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

санал дүгнэлт өгсөн нь өмнөх оноос дүгнэлт гаргасан байгууллагын тоо 2 байгууллагаар, зөрчилгүй дүгнэлт 11 байгууллагаар тус тус нэмэгдэн, хязгаарлалтай дүгнэлт 6 байгууллагаар, санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт 1 байгууллагаар, сөрөг санал дүгнэлт 1 байгууллагаар тус тус буурсан үзүүлэлтэй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17338.06 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 79.8 хувь буюу 13851.0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 63.8 сая төгрөг буюу 0.4 хувьд төлбөрийн акт, 973.9 сая төгрөг буюу 5.6 хувьд батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулсан, төсвийг зохистой удирдаагүй, өр авлага үүсгэсэн, нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй зэрэг зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг арилгах, албан шаардлага өгч ажилласан бол 2449.5 сая төгрөг буюу 14.2 хувьд материаллаг бус алдаа зөрчлийг арилгах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ оны санхүүгийн тайлангийн аудитаар Орхон аймгийн Татварын хэлтэс, 4-р цэцэрлэг, 26-р цэцэрлэг, Жаргалант сумын ЗДТГ, Баян-Өндөр сумын ИТХ, Учралтбаяр ӨЭМТ, Орхон АЗЗА ТӨХК зэрэг 7-н байгууллага хязгаарлалттай санал дүгнэлт авчээ.

Өмнөх оноос зөрчлийн тоо 35-р буюу 16169.3 сая, залруулсан алдаа 11-р буюу 14744.2 сая, материаллаг бус алдаа зөрчлийг арилгах зөвлөмж 16-аар буюу 696.8 сая, албан шаардлага 24-өөр буюу 371.9 сая төгрөгөөр тус тус буурч, төлбөрийн акт 13-аар буюу 8.0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Аймгийн ТЭЗ-д 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан 5 байгууллагын холбогдох албан хаагчдад Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу арга хэмжээ авхуулахаар албан шаардлага хүргүүлэн, биелэлтийг хангуулан ажиллаа.

2020 оны Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалтад үндэслэн аудит хийх хэлбэрийг байгууллага тус бүрээр, санхүүгийн тайланд аудит хийх журмын 10.7-д заасан нөхцөл шаардлагын дагуу сонгож, А30101 нэгтгэн баталгаажуулж, журмын 10.8-д заасны дагуу байгууллагын 194 дүгээр албан бичгээр ҮАГ-ын Стратегийн удирдлагын газарт хүргүүлсэн.

2020 оны санхүүгийн тайланд 129 байгууллага хамруулахаас 13 байгууллагад итгэл үзүүлэх, 78 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргах, 24 байгууллагын санхүүгийн тайланд аудит гэрээгээр хийлгэх, 14 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийхээр санал хүргүүлж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/64 дүгээр тушаалаар батлуулаад байна.

МУЕА-ын А/64 дугаар тушаалаар батлагдсан 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагуудын хуваарийг гарган баталгаажуулж, санхүүгийн тайлангийн явцын аудитыг гүйцэтгэн, санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн ажил хийгдэж байна.

Аймгийн ТЭЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтын хүрээнд Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийсэн.

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, УСНББОУС, СТОУС, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журмууд, Санхүүгийн тайлангийн аудитын журмын хүрээнд Орхон аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 83 төсвийн байгууллага, 7 ОНӨААН, 2 төрийн сан, төрийн сангийн хамаарах данс /Өрхийн эмнэлэг, хувийн сургууль, хувийн цэцэрлэг, Ахмадын хороо, УТХО, УТТО, ТӨХОСС зэрэг 7 данс/ нийт 99 байгууллага аудитад хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 6 байгууллагыг түүвэрт хамруулж, 13 байгууллагад итгэл үзүүлж, 80 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 75, “Хязгаарлалттай” 5 /4-р цэцэрлэг, Баян-Өндөр сумын ИТХ, 26-р цэцэрлэг, Жаргалант сумын ЗДТГ, Учралтбаяр ӨЭМТ/ дүгнэлт өгсөн байна.

Орхон аймгийн ТЭЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 14232.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 12823.7 сая төгрөгийн алдааг залруулж, 29.6 сая төгрөгийн зөрчилд 53 төлбөрийн акт тогтоож, 701.7 сая төгрөгийн зөрчилд 39 албан шаардлага, 1409.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 288 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 0.65 сая төгрөгөөр авлагыг илүү, 1.03 сая төгрөгөөр бараа материалыг илүү, 0.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг хөрөнгийг дутуу, 5.74 сая төгрөгөөр өр төлбөрийг дутуу, 2223.03 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг илүү, Өмч /төрийн/ /ТӨҮГ/-ийг 2216.1 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийтлэг татварын бус орлогыг 2047.28 сая төгрөгөөр илүү, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 11.8 сая төгрөгөөр илүү, АО-с төлөх НДШ-ийн зардлыг 0.2 сая төгрөгөөр дутуу, хангамж бараа материалын зардлыг 89.7 сая төгрөгөөр дутуу, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.15 сая төгрөгөөр илүү, бараа үйлчилгээний бусад зардлыг 5.99 сая төгрөгөөр дутуу, үйл ажиллагааны бус зардлыг 91.8 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг 0.04 сая төгрөгөөр дутуу, 2216.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн өсөлт бууралтыг дутуу, 2223.07 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 9.4 сая төгрөгөөр нийтлэг татварын бус орлогыг илүү, 0.98 сая төгрөгөөр хангамж, бараа материалын зардлыг илүү, 9.4 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг илүү, 3.5 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг дутуу, 0.98 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийг дутуу, хөрөнгийн зардлыг 3.5 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 1.26 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг дутуу нэгтгэсэн байна.



Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн байгууллагаас 6 байгууллагад итгэл үзүүлж, 12 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 68, Хязгаарлалттай 5 /4-р цэцэрлэг, Баян-Өндөр сумын ИТХ, 26-р цэцэрлэг, Жаргалант сумын ЗДТГ, Учралтбаяр ӨЭМТ/ санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2833.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,505.0 сая төгрөгийн алдааг залруулж, 28.2 сая төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоож, 699.0 сая төгрөгийн зөрчилд 34 албан шаардлага, 601.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 174 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж байгууллагаас 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 6 санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 181.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 156.5 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 2.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 20.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.

Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж зөрчилгүй дүгнэлт гаргасан байна.

Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 238.3 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрч, 0.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 0.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 237.2 сая төгрөгийн материаллаг бус алдаа зөрчлийг арилгах 5 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Өмнөх оноос алдаа зөрчил 46.0 сая төгрөг буюу 4, зөвлөмж 65.0 сая төгрөг буюу 3-аар тус тус нэмэгдсэн байна.

Улсын төсвөөс санхүүждэг төсвийн шууд захирагч байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

Улсын төсвөөс санхүүждэг төсвийн шууд захирагч 24 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхээс 7 байгууллагад итгэл үзүүлэн, төрийн аудитын газар 12 байгууллагад, хувийн аудит 5 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Төсвийн шууд захирагч 17 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргаснаас зөрчилгүй санал дүгнэлт 16 байгууллагад, аймгийн татварын хэлтсийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт тус тус хүргүүлсэн.

Улсын төсвөөс санхүүждэг төсвийн шууд захирагч 17 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 1230.7 сая төгрөгийн 97 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 840.6 сая төгрөгийн 36 залруулга хийн, 20.8 сая төгрөгийн 9 төлбөрийн акт тогтоож, 150.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 42 албан шаардлага, 218.7 сая төгрөгийн материаллаг бус алдаа зөрчлийг арилгах 32 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Өмнөх оноос алдаа зөрчил 5508.0 сая төгрөг буюу 21-ээр, залруулсан алдаа 5402.0 сая төгрөг буюу 3-аар, зөвлөмж 60.0 сая төгрөг буюу 5-аар, төлбөрийн акт 18.0



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

сая төгрөг буюу 2-оор, албан шаардлага 27.0 сая төгрөг буюу 11-ээр тус тус буурсан байна.

Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

Халамжийн сан болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд аудит хийж зөрчилгүй дүгнэлт гаргасан.

Халамжийн сан болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлангийн аудитаар 113.4 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 57.2 сая төгрөгийн 1 залруулга хийн, 18.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 37.3 сая төгрөгийн материаллаг бус алдаа зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

Орхон "Авто тээврийн төв" ТӨҮГ-ын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, "Орхон АЗЗА" ТӨХК санхүүгийн тайланд аудит хийж хязгаарлалтай дүгнэлт гаргасан. Аудитаар 181.7 сая төгрөгийн 17 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 129.6 сая төгрөгийн 3 залруулга хийн, 13.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 33.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 5.3 сая төгрөгийн материаллаг бус алдаа зөрчлийг арилгах 6 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

"Орхон АЗЗА" ТӨХК-ны ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч нь 2019 оны 07 сард урьдчилгаа цалин 2000.0 мянган төгрөг, 2019 оны 09 сард урьдчилгаа цалин 1000.0 мянган төгрөгийг өөрийн харилцах дансанд илүү шилжүүлж, банканд очих жагсаалт болон байгууллагад үлдэх анхан шатны баримтыг 2 өөрөөр үйлдэж, ашиглалын шинжтэй үйлдэл гаргаж нягтлан бодогчийн ёс зүйг зөрчсөн.

Мөн тус байгууллагын шатахуун нийлүүлдэг НИК ХХК-тай тооцоо нийлсэн актаар 7285.4 мянган төгрөгийн өглөгтэй байтал уг өглөгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байх тул байгууллагын тооцооны нягтлан, гүйцэтгэх захирал нараас тодруулахад, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч харилцагч байгууллагаас бэлнээр мөнгийг нь гаргуулж авсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Гэрээгээр гүйцэтгүүлсэн аудитын талаар

МУЕА-ийн 2017 оны А/191 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам"-ын дагуу санхүүгийн тайлангийн аудитыг ХАК-аар гэрээгээр гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээний ТББ, ажлын даалгаврыг боловсруулан, тендер зарлагдаж, оролцох мэдүүлгээ ирүүлсэн 4 байгууллагуудад тендерийн урилга хүргүүлэн, Санхүүгийн тайлангийн аудитыг ХАК-аар гэрээгээр гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээний тендерийн техникийн саналын үнэлгээ хийн, "Далай ван" аудит ХХК-ийн Орхон салбар, "Мэжик консалтинг" аудит ХХК-ийн Орхон салбарууд тус тус шалгарсан. "Далай ван" аудит ХХК-ийн Орхон салбар, "Мэжик консалтинг" аудит ХХК-ийн Орхон салбартай 2019 оны 11 сарын 15-ны өдөр Санхүүгийн тайлангийн аудитыг хараат бус аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх ОР-ТАГ-01/2019 гэрээг байгуулан "Далай ван" аудит ХХК-ийн Орхон салбар төсвийн шууд захирагч 10 байгууллага, 1



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ОНӨААН, “Мэжик консалтинг” аудит ХХК-ийн орхон салбар төсвийн шууд захирагч 10 байгууллага, 1 ОНӨААН-ийн санхүүгийн тайланд аудит хийсэн.

2019 онд 23 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас, 20 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалтай” санал дүгнэлт өгч байсан бол 2020 онд 22 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас 21 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалтай” санал дүгнэлт гаргаж ажилласан.

Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 516.9 сая төгрөгийн 67 алдаа зөрчил илэрч, алдаа зөрчлийн 18.5 хувь буюу 95.9 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 1.1 хувь буюу 5.6 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 73.7 хувь буюу 381.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага хүргүүлж, 6.7 хувь буюу 33.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 37 зөвлөмж тус тус хүргүүлэн ажиллаа.

МУЕА-ийн 2020 оны А/81 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу 2019 оны санхүүгийн тайланд аудит хийсэн Далай ван аудит ХХК-ийн Орхон салбар 86.4, “Мэжик консалтинг” аудит ХХК-ийн Орхон салбар 86.2 хувиар үнэлэгдсэн. Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын 3.6-д заасны дагуу “Далай ван” аудит ХХК-ийн Орхон салбар, “Мэжик консалтинг” аудит ХХК-ийн Орхон салбартай 2020 оны 12 сарын 04-ны өдөр Санхүүгийн тайлангийн аудитыг хараат бус аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх 01, 02 гэрээ /ТШЗ-22, ОНӨААН-2, нийт 24 байгууллагад СТА хийх/-г байгуулан, завсарын аудит эхэлсэн.

2.1.2 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд Орхон аймгийн 2019 оны төсвийн нийт зарлага 93559.8 сая төгрөг, үүнээс орон нутгийн суурь зарлага 14874.8 сая төгрөг, хөрөнгө оруулалт 23221.7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зарлага 34491.0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4671.4 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 16300.9 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 12/04 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 55898.8 сая төгрөгөөр баталсан нь Сангийн яамнаас хянасан нийт орлогоос 6247.2 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Сангийн яамны хянасан орлогоос аймгийн ИТХ-иар төсвийн орлогыг батлахдаа дараах орлогыг нэмж баталсан байна. Үүнд:

- Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого 550.5 сая төгрөг
- Хадгаламжийн хүүгийн орлого 200.0 сая төгрөг
- Газрын төлбөр 4900.0 сая төгрөг
- Ус рашаан нөөц ашигласны төлбөр 280.0 сая төгрөг
- Төсвийн байгууллагын өөрийн орлого 116.7 сая төгрөг
- Хүү торгуулийн орлого 200.0 сая төгрөг



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 12/04 дүгээр тогтоолоор орон нутгийн зарлагыг 17237.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд Сангийн яамны хянасан орлогоос 3773.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж батлагджээ.

Орхон аймгийн 2019 оны орлого зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн 12/04 дүгээр тогтоолоор 103014.4 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. Үүнээс: татварын орлогыг 55007.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 891.6 сая төгрөгөөр, тусламжийн орлогыг 39740.3 сая төгрөгөөр, урьд оны шилжих үлдэгдлийг 7375.3 сая төгрөгөөр баталсан бол 69790.8 сая төгрөгийг урсгал зардалд, 33223.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тусган баталжээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 1165.7 сая төгрөг, сумдын ИТХ-ын хуралдаанаар 175.6 сая төгрөгийг төсөвт нэршил өөрчлөх, шилжүүлэх нэрээр төсөвт тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Хөрөнгө оруулалтын ажлыг бодитой төлөвлөөгүйгээс, төсөв батлагдсанаас хойш 5 удаагийн ИТХ-ын тогтоолоор 714.8 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг 24 төсөл арга хэмжээ болгосон, хооронд нь шилжүүлж 33.4 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг шинээр нэмсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 12781.4 сая төгрөг буюу 13.2 хувиар давуулан биелүүлж, зарлагын гүйцэтгэл 89.3%-тай, улсын төсөвт төвлөрүүлэх 16300.9 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.



Аудитаар улсын төсөвт 16300.9 сая төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 113.2 хувиар биелүүлэн, төсвийн зарлагын гүйцэтгэл 89.3 хувьтай байна гэсэн дүгнэлт өгч, аудитын тайланг 2020 оны А/06 дугаар тушаалаар баталгаажуулан, ҮАГ, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-н СТСХэлтэст тус тус хүргүүлэн ажиллаа.

2.1.3 Санхүүгийн тайлангийн аудитын статистик үзүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар 17338.06 сая төгрөгийн 539 алдаа зөрчил илрүүлснээс, санхүүгийн тайлангуудад 13851.0 сая төгрөгийн 156 материаллаг алдааг залруулж, 2449.5 сая төгрөгийн материаллаг бус алдаа зөрчлийг арилгах 255 зөвлөмж өгч, 63.7 сая төгрөгийн 65 төлбөрийн акт тогтоож, 973.9 сая төгрөгийн 58 албан шаардлага тус тус хүргүүлэн, өмнөх оноос зөрчлийн тоо 35-р буюу 16169.3 сая, залруулсан алдаа 11-р буюу 14744.2 сая, материаллаг бус алдаа зөрчлийг арилгах зөвлөмж 16-аар буюу 696.8 сая, албан шаардлага 24-р буюу 371.9 сая төгрөгөөр тус тус буурч, төлбөрийн акт 13-р буюу 8.0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтэй байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Зөвлөмж: 2020 оны эхний байдлаар зөвлөмжийн хэрэгжээгүй үлдэгдэл 422.9 сая төгрөгийн 9 зөвлөмжийн үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 2449.5 сая төгрөгийн 255-р нэмэгдэн, нийт 2872.4 сая төгрөгийн 264 зөвлөмж бүртгэгдсэнээс, энэ онд өмнөх оны 422.9 сая төгрөгийн 9, энэ оны 2422.05 сая төгрөгийн 252 зөвлөмжийг хэрэгжүүлэн, 27.4 сая төгрөгийн 3 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд зөвлөмжийн 98.8 хувь, үнийн дүнгийн 99.1 хувийг биелүүлсэн байна.

Төлбөрийн акт: 2020 оны эхэнд 7 төлбөрийн актын хэрэгжээгүй үлдэгдэл 12.6 сая төгрөг, тайлант онд гүйцэтгэсэн аудитаар 63.7 сая төгрөгийн 65 акт нэмж бүртгэгдэн, нийт 76.3 сая төгрөгийн 72 актаас, өмнөх оны 1 актын 0.20 сая, энэ оны 46.8 сая төгрөгийн 61 актын биелэлтийг хангуулан, орон нутгийн төсөвт 47.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 16.9 сая төгрөгийн 4 акт хугацаа хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд төлбөрийн актын 94.4 хувь, үнийн дүнгийн 77.8 хувийг биелүүлсэн байна.

Албан шаардлага: 2020 оны эхэнд 234.4 сая төгрөгийн 2 албан шаардлагын үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 973.8 сая төгрөгийн 58 албан шаардлага нэмж бүртгэгдэн, нийт 1208.2 сая төгрөгийн 60 албан шаардлагаас, өмнөх оны 231.6 сая төгрөгийн 1 албан шаардлага, энэ оны 794.7 сая төгрөгийн 50 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 181.8 сая төгрөгийн 9 албан шаардлага хугацаа хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд албан шаардлагын 85.0 хувь, үнийн дүнгийн 84.9 хувийг биелүүлсэн байна.



Үр өгөөж: Тайлант хугацаанд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн 6823.8 сая төгрөгийн 63 үр өгөөж бүртгэн, хүлээн зөвшөөрүүлж ажиллаа.

Дээрх үзүүлэлтээс харахад зөвлөмжийн 98.8 хувийг, төлбөрийн актын 94.4 хувийг, албан шаардлагын 85.0 хувийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу байгууллагын дарга эрхлэгч, нягтлан бодогч 5 хүнд арга хэмжээ тооцох саналыг дээд шатны удирдлагад хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаа.

2019 оны СТА-аар “Унага” цэцэрлэгийн нягтлан бодогч харилцагч байгууллагаас бэлэн мөнгө гаргуулан авсан байж болзошгүй асуудлыг Цагдаагийн газарт шилжүүлэн хэрэг үүсэн шалгагдаж, шүүхэд шилжсэн байна.

2.2 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ: Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу нэгдсэн удирдамжтай “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө,” Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”, “Улсын их хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”, “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”, өөрсдийн санаачилгаар хийгдэх “Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүн”, Аймгийн ИТХ-ын захиалгаар “Орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн явц байдал” гүйцэтгэлийн аудитуудыг төлөвлөсөн хугацаанд хийж, аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Дээрх аудитад давхардсан тоогоор 6 хүн, 246 өдөр зарцуулан 398 цаг илүү ажилласан байна.

2.2.1 Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө гүйцэтгэлийн аудит.

Орхон аймагт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 56871.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдаж, 39072.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн.

2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээнд аймгийн Засаг дарга санал хүргүүлээгүй байна.

Баталгаажсан зураг, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг УИХ-аар тойм дүнгээр батлаад байгаа нь магадлалын дүгнэлтээр баталгаажсаны дараа төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болсон байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилт олгохдоо 8 төсөл, арга хэмжээний захиалагчийн болон зохиогчийн хяналт, зураг төсвийн зардал, барьцааны 811.0 сая төгрөгийн зардлыг суутгахгүйгээр олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аудитаар нийт 851.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 851.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал, 4 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг хүргүүллээ.

Аудитын тайланг 2020 оны А/07 дугаар тушаалаар баталгаажуулан, ҮАГ, аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, ХББЗА ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.

2.2.2 Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн гүйцэтгэлийн аудит.

Төрийн өмчийн сургуулиудын хувьд Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д эцэг эх, асран хүмүүжүүлэгч “хүүхдээ аль сургуульд, ямар хэлбэрээр суралцуулахыг зохих журмын дагуу сонгох” гэж заасан хэдий ч мөн хуулийн 28¹ дугаар зүйлийн 28¹.1.6-д аймаг, нийслэлийн Боловсролын газар “орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох” бүрэн эрхтэй байхаар заасан нь уялдаагүй байна.

Хуулийн уялдаагүй байдлаас шалтгаалан томоохон хотуудад хамран сургах тойргийн дагуу бус төвлөрсөн хэсэгт анги дүүргэлт ачаалал ихсэн, сургалтын чанар хүртээмж буурч, төсөвт зардал баталдаггүйгээс холбогдох журам, дүрмийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсжээ.

2019-2020 оны хичээлийн жилд төрийн өмчийн 17, хувийн хэвшлийн 7 сургуулийн 712 бүлэгт 21,461 хүүхэд суралцсан бөгөөд анги дүүргэлт бага ангид 34.0, дунд ангид 27.5, ахлах ангид 25.6 байна. Орхон аймгийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулиуд өөрийн эзэмшлийн 28 барилга, байгууламжтай бөгөөд барилгын насжилтыг авч үзвэл 40-өөс дээш жилийн насжилттай барилга 7 байна. Төрийн бус өмчийн 2, төрийн өмчийн 1 сургууль түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна.

Хотын төвийн сургуулиудад багшийн хүрэлцээ хангалттай бөгөөд сонгон шалгаруулалтаар эсвэл дадлага туршлагатай багшид санал тавих байдлаар шийдвэрлэдэг байна. Харин хотын захын сургуулиудад хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөртэй уялдуулан хосолсон мэргэжлийн багш ажиллуулахад хүндрэлтэй бөгөөд тухайлсан судлагдахуунаар мэргэшсэн байх боловч ажлын байранд тавигдах шаардлага хангахгүй байх, шинээр авч дадлагажуулж, туршлагажсан багшийг тогтвортой ажиллуулах бодлого байхгүйгээс өөр сургуульд шилжих зэрэг хүндрэл бэрхшээл үүсдэг байна.

Төрийн бус өмчийн ЕБС-ийн санхүүжилтийг Засгийн газрын 242 дугаар тогтоолын 4.4-т “төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын төлөвлөлт, хуваарилалт, санхүүжилт, хяналтыг санхүүжих дундаж хүүхдээр тооцно. Санхүүжих дундаж хүүхдийн тоо нь тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоо болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөөр баталсан хүүхдийн тооноос ихгүй байна”, 4.5-д “хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу улирал тутам олгоно” гэж заасны дагуу олгох байтал тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоогоор тооцоогүй байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 – 2019 онд тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоогоор тооцохгүйгээр 376.5 сая төгрөгийн хувьсах зардлын санхүүжилтийг илүү олгосон байна.

Аудитаар нийт нийт 126.1 сая төгрөгийг төлбөрийн акт, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 5 зөвлөмжийг холбогдох газарт, аудитын тайланг 2020 оны А/22 дугаар тушаалаар баталгаажуулан, ҮАГ, аймгийн Засаг дарга, Боловсрол соёл, урлагийн газарт тус тус хүргүүлсэн.

2.2.3 Улсын их хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах.

УИХ-ын 2020 оны сонгуулийг зохион байгуулах Орхон аймгийн сонгуулийн хорооны зардалд СЕХ-ноос 206.4 сая төгрөгийн төсвийг баталсан, гүйцэтгэлээр 205.58 сая төгрөгийг зарцуулж, 0.85 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

УИХ-ын 2020 оны сонгуульд Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр, Жаргалант сумдын 38 хэсгийн хороо байгуулагдаж, нийт 406 төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч ажилласан, УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд 66830 сонгууль өгөх насны хүн бүртгэгдсэнээс 45691 иргэн саналаа өгчээ.

Сонгуулийн зардлыг аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр, Жаргалант сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодод СЕХ-ноос 5 удаагийн сонгуулийн зардлын төсвийн тайлбар, аргачлал, зөвлөмжийг ирүүлж, түүний дагуу тооцон хуваарилжээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5-д “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” 11.5.1-д “Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, эрсдэлийг бууруулах” гэж заасны дагуу COVID-19 цаг үеийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн сонгуулийн хорооны төсөвт болзошгүй зардалд 2.0 сая төгрөгийн тусгаж батлан, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор санал авах 38 хэсгийн хорооны санал авах байрны 419173 м² дотор, гадна талбайд ариутгал хийжээ.

УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулалтад журмын дагуу хяналт хэрэгжүүлж ажилласан байна” гэсэн дүгнэлт өгч аудитын тайланг 2020 оны А/17 дугаар тушаалаар баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.

2.2.4 Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах.

Сонгуулийн Ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбогдуулан нийт 201,675.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт зардлын 75 хувь буюу 151,137.0 мянган төгрөгийг сумын сонгуулийн хороонд, 25 хувь буюу 50,538.0 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар хуваарилжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10.2-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу УБЕГ-аас аймгийн УБХ-т 29,543.0 мянган төгрөг, 10.3-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт 5.280.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журмын 4.1-т “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасны дагуу бүртгэж тайлагнасан.

Аудитын тайланг 2020 оны А/27 дугаар тушаалаар баталгаажуулан аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсэн.

2.3 Гүйцэтгэлийн аудитын статистик үзүүлэлт

Зөвлөмж: 2020 оны эхэнд зөвлөмжийн хэрэгжээгүй үлдэгдэл 5853.5 сая төгрөгийн 37, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 1303.0 сая төгрөгийн 24 зөвлөмж өгч, нийт 7156.5 сая төгрөгийн 61 зөвлөмжөөс, өмнөх оны 5853.5 сая төгрөгийн 27 зөвлөмж, энэ оны 2 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан, үлдэгдэл 1303.0 сая төгрөгийн 32 зөвлөмжөөс, 12 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1303.0 сая төгрөгийн 20 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд зөвлөмжийн 67.2 хувь, үнийн дүнгийн 81.8 хувийг биелүүлсэн байна.

Төлбөрийн акт: 2020 оны эхэнд төлбөрийн актын хэрэгжээгүй үлдэгдэл 150.9 сая төгрөгийн 19 акт, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 134.7 сая төгрөгийн 3 акт өгч, нийт 285.6 сая төгрөгийн 22 актаас, өмнөх оны 1.7 сая төгрөгийн 3 акт, энэ оны 16.1 сая төгрөгийн актын биелэлтийг хангуулан, үлдэгдэл 249.3 сая төгрөгийн 3 актаас, 118.6 сая төгрөгийн 2 акт хэрэгжих шатандаа, 130.7 сая төгрөгийн 1 акт хугацаа хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд төлбөрийн актын 86.3 хувь, үнийн дүнгийн 12.7 хувийн хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

Албан шаардлага: 2020 оны эхэнд 268.3 сая төгрөгийн 7 албан шаардлагын үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 4434.8 сая төгрөгийн 15 албан шаардлага нэмж бүртгэгдэн, нийт 4703.1 сая төгрөгийн 22 албан шаардлагаас, өмнөх оны 266.7 сая төгрөгийн 5, энэ оны 574.3 сая төгрөгийн 10 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 3860.1 сая төгрөгийн 7 албан шаардлагын үлдэгдэлтэйгээс 2915.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хэрэгжих шатандаа, 944.3 сая төгрөгийн 5 албан шаардлага хугацаа хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд албан шаардлагын 25.0 хувь, үнийн дүнгийн 14.9 хувийг биелүүлсэн, хэрэгжээгүй албан шаардлагын 1519.0 сая төгрөгийн 13 албан шаардлага хэрэгжих шатандаа, 1.6 сая төгрөгийн 2 албан шаардлага хугацаа хэтэрсэн байна.

Үр өгөөж: Тайлант оны гүйцэтгэлийн аудитад 211 байгууллага хамруулж, 6266.2 сая төгрөгийн 46 алдаа зөрчил илрүүлэн, санхүүгийн 7778.3 сая төгрөгийн 22 үр өгөөж, санхүүгийн бус 23 үр өгөөж бүртгэн, хүлээн зөвшөөрүүлж ажиллаа.

Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 4 албан хаагчид арга хэмжээ тооцох саналыг дээд шатны удирдлагад хүргүүлж, 1 албан хаагчид хариуцлага тооцуулан, 3 албан хаагчид хариуцлага тооцуулах албан шаардлага биелэлт хангагдаагүй байна.

Өмнөх оны аудитаар хуулийн байгууллагад шилжүүлсэн 131.5 сая төгрөгийн 3 асуудал хэрэг үүсгэн шалгагдаж байгаа.

2.3 НИЙЦЛИЙН АУДИТ



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ: Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу, нэгдсэн удирдамжтай Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт нийцлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь гүйцэтгэн, тушаалаар баталгаажуулж, тайлан судалгааг ҮАГ-т болон аймгийн Засаг дарга, ИТХ, сумдын ЗДТГ-т хүргүүлэн ажиллаа.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох”, “Нам эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах”, “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гарган нийтэд мэдээлэх” нийцлийн аудит хийгдсэн.

Дээрх аудитуудад давхардсан тоогоор 21 хүн 216 өдөр зарцуулан, 142 цаг илүү ажиллан, 532 байгууллага хамруулсан байна.

2.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудит.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

№	Шилэн дансны тухай хуулийн 3.1-д хамаарах хуулийн этгээд	Хэлбэр	Тоо
1	Хуулийн 3.1.1-д хамаарах	ТӨХЭ, ОНӨХЭ, ОНӨААТҮГ, ОНӨҮГ	113
2	Хуулийн 3.1.2-д хамаарах	ТӨҮГ, ТӨААТҮГ	2
3	Хуулийн 3.1.3-д хамаарах	ХК, ТӨХК	3
4	Хуулийн 3.1.4-д хамаарах	иргэн, ААН	116
5	Хуулийн 3.1.5-д хамаарах	ӨЭМТ, Хувийн өмчийн сургууль, цэцэрлэг	22
Нийт дүн			256

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд:

- ❖ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах нийт 115 байгууллагын цэс үүсгэгдэж, тогтмол мэдээлэх мэдээллээс 92.24 хувийг хугацаанд нь мэдээлсэн байна.
- ❖ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлэхгүй байна.
- ❖ Байгууллагууд шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлж байна.
- ❖ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах ХК-уудын 20 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэсгүй байна.
- ❖ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах ХК-ууд шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг дутуу мэдээлсэн байна.
- ❖ Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах ААНБ-уудын 26 хувь нь шилэн дансны цахим хуудаст мэдээлэх эрх нээлгэсэн байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- ❖ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд холбогдох хууль, журамд заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй байна.
- ❖ Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасан мэдээллийг мэдээлэх эрхийг бүрэн нээлгэсэн байна.
- ❖ Хуулийн 3.1.5-д хамаарах ихэнх байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд санхүүжилтийн талаар огт мэдээлээгүй байна
- ❖ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хөгжлийн хороо 2019 оны 1-4 дүгээр улирлын хуулийн хэрэгжилтийг шалгасан дүнг хэлэлцэн, чиглэл хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажилласан, Баян-Өндөр, Жаргалант сумдын ИТХ-аас хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
- ❖ Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.
- ❖ Өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмж биелээгүй байна.

Аудитын илрүүлэлт, аудитын дүгнэлтэд үндэслэн “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-д 1, Боловсрол соёл урлагийн газарт 1, “Орхон АЗЗА” ТӨХК-д 1, Баян-Өндөр сумын ИТХ-д 1, Жаргалант сумын ИТХ-д 1, нийт 5 албан шаардлага, аймгийн Засаг даргад 2, “Эрдэнэт Дулааны Цахилгаан Станц” ТӨХК, “Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-иудад 1, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захиралд 1, нийт 7 зөвлөмж тус тус хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаа.

Аудитын тайланг 2020 оны А/08 дугаар тушаалаар баталгаажуулан, ҮАГ, аймгийн Засаг дарга, Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга болон ИТХ-д тус тус хүргүүлсэн.

2.3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор Орхон аймгийн 2019 оны орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өндөр сумд 988.9 сая төгрөг, Жаргалант сумд 904.2 сая төгрөгийг хуваарилсан байна. Сумдын хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан үзэж сумдад олгох орлогын шилжүүлгийг хуваарилсан талаарх тооцоолол аймаг дээр хийгдээгүй байна. Сангийн яаманд тооцоолол хийгдсэн гэх боловч яг аргачлалын дагуу хийгдсэн эсэх талаар нотлох баримт байхгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор 2019 онд 2 суманд СОНХС-ийн хөрөнгөөр нийт 1893.2 сая төгрөгийн ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна. Төсвийн тухай хуулийн 63.1, 63.2 заалт болон Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1, 3.1.2 -т заасныг зөрчин иргэдийн саналаар гарч эрэмбэлэгдээгүй ТАХ хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 58.4 дүгээр зүйлд сум өөрийн төсвөөр хэрэгжүүлэх ТАХ-ний чиг үүргийг тодорхойлсон байна.

Гэтэл дараах сумдад Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй болон урсгал зардлын шинжтэй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Баян-Өндөр сумын Баянцагаан соёлын төвд эд хогшил худалдан авахад 16.7 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Хэмнэл соёлын төвд эд хогшил худалдан авахад 9.7 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төвд эд хогшил худалдан авахад 5.0 сая төгрөг,



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- Баян-Өндөр сумын ЗДТГ-т Мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж худалдан авахад 15.0 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын ЗДТГ-т спортын тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авахад 15.0 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж худалдан авахад 15.1 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Ирээдүйн одод сургуулийн мэдээлэл зүйн кабинетын тохижилтын тохижилтод 15.0 сая төгрөг,
- БОЭТ, 11-р цэцэрлэг, багийн ахмадын байранд тоног төхөөрөмж худалдан авахад 8.0 сая төгрөг,
- Жаргалант сумын цэцэрлэгт ширээ, сандал худалдан авахад 8.8 сая төгрөг,
- Жаргалант суманд Улс, аймгийн зэрэглэлтэй спортын бага наадам, уралдаан тэмцээнийг зохион байгуулах зардалд 10.7 сая төгрөг ,
- Орхон аймгийн хэмжээнд 3000 залуучуудын цугларалтад Жаргалант сумаас оролцох 100 залууст хувцас, цүнх худалдан авч өгөхөд 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтэд ИТХ-н дэргэдэх Хяналтын хороо болон иргэд иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй байна

Аудитын тайланг 2020 оны А/26 дугаар тушаалаар баталгаажуулан, ҮАГ, аймгийн Засаг дарга, Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга болон ИТХ-д тус тус хүргүүлсэн

2.3.3 Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49.1."Энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ" гэсэн заалтын дагуу аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын хэмжээг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийн, Захиргааны ерөнхий хуулийн 26.1-д заасны дагуу сонсох ажиллагаа явуулж, 2020 оны А/15 дугаар тушаалаар баталгаажуулан, Орон нутгийн 3 телевиз, нэг сайтаар дамжуулан нам эвсэл, иргэд олон нийтэд мэдээлж, Orkhon.audit.mn вэб хуудсан дээр байршуулсан.

2.3.4 Нам эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 37.10. 37.11 дэх заалтын дагуу орон нутагт салбар бүхий 7-н улс төрийн намд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу мөрийн хөтөлбөрөө ирүүлэх, дүгнэлт гаргуулах тухай захидал хүргүүлж, мөрийн хөтөлбөр хүлээн авч Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл нам /ШИНЭН/, Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/, Монголын Социал Демикрат нам /МСДН/, Монгол Ардын нам /МАН/, Иргэний Зориг Ногоон нам /ИЗНН/, Хөдөлмөрийн Үндэсний нам



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

/ХҮН/, Иргэний Хөдөлгөөний нам /ИХН/, Ардчилсан нам /АН/-ын мөрийн хөтөлбөрт аудитын дүгнэлт гарган Аймаг, сумын сонгуулийн хороо болон намд гардуулан өгсөн.

Орон нутгийн сонгуульд бие даан нэр дэвших хүсэлт гаргасан 78 иргэний материалыг хүлээн авч 75 иргэний мөрийн хөтөлбөрт аудитын дүгнэлт гарган Аймгийн болон Баян-Өндөр сум, Жаргалант сумдын сонгуулийн хороо болон иргэдэд гардуулан өгсөн. ИТХ-д бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт болон намын мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг скайнерден PDF болгон цахим мэдээллийн санд байршуулах ажлыг хийж гүйцэтгээд байна.

2.3.5 Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гарган нийтэд мэдээлэх.

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцогчдын сонгуулийн зардалтай холбоотой журам, маягт, заавар, аргачлалыг ҮАГ-аас баталсан маягт, заавар, аргачлалын хүрээнд боловсруулан Аймгийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторын А/19 тоот тушаалаар батлуулсан. Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцогчдын сонгуулийн зардлын тайланг ирүүлэх тухай Аймгийн ИТХ-н сонгуульд оролцсон 5, Баян-өндөр сумын ИТХ-н сонгуульд оролцсон 4, Жаргалант сумын ИТХ-д сонгуульд оролцсон 3 нам болон 16 бие даагчид албан тоор тус тус хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-56.4-т заасны дагуу нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ гэсэн заалтын дагуу “Мөнгө нөөц баялаг-Аудит” ХХК, “Шинэ баланс-Аудит” ХХК, “Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбар, “Итгэл найдвар од аудит” ХХК, “ЦЭСБ-АУДИТ” ХХК-иуд сонгуулийн зардлын тайланд аудит хийх гэрээ байгуулсан.

Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд 5 намын 201 нэр дэвшигч 20 бие даагч нийт 221 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хараат бус аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан ирүүлэхээс 3 нам /МАН, АН, МАХН/, 5 намын /МАН, АН, МАХН, ХҮН, ШИНЭН/ 154 нэр дэвшигч, 20 бие даан нэр дэвшигч нийт 174 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн, хуулийн хугацаандаа зардлын тайлангаа ирүүлээгүй ирүүлээгүй 2 нам /ХҮН, ШИНЭН/, 47 нэр дэвшигч байна. Үүнд: АН-25, МАХН-14, ШИНЭН-6, ХҮН-2

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу зардлын тайланг хянаж нийтэд мэдээлэх үүрэгтэй гэсэн заалтын дагуу хуулийн хугацаанд зардлын тайлангаа хараат бус аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан ирүүлсэн 3 нам /МАН, АН, МАХН/, 5 намын /МАН, АН, МАХН, ШИНЭН, ХҮН/ 154 нэр дэвшигч, 20 бие даан нэр дэвшигч нийт 174 нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж дүнг мэдээлэх ажил хийгдэж байна.

4.3 Нийцлийн аудитын статистик үзүүлэлт

Зөвлөмж: 2020 оны эхний байдлаар зөвлөмжийн хэрэгжээгүй үлдэгдэл 8, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 1722.5 сая төгрөгийн 19, нийт 1722.5 сая төгрөгийн 27 зөвлөмж бүртгэгдэн, энэ онд 14 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан, 1722.5 сая төгрөгийн үлдэгдлээс 1722.5 сая төгрөгийн 12 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлбөрийн акт: 2020 оны эхний байдлаар төлбөрийн 210.9 сая төгрөгийн 2 актын үлдэгдэлтэйгээс, 122.2 сая төгрөгийн биелэлт хангагдаж, 2 актын 88.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн байна.

Албан шаардлага: 2020 оны эхний байдлаар 121.1 сая төгрөгийн 3 албан шаардлагын үлдэгдэлтэй, энэ онд гүйцэтгэсэн аудитаар 5 албан шаардлага нэмж бүртгэгдэн, нийт 121.1 сая төгрөгийн 8 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Үр өгөөж: Энэ онд хийгдсэн 5 нийцлийн аудитад 532 байгууллага хамрагдаж, санхүүгийн 122.2 сая төгрөгийн 8, санхүүгийн бус 5 үр өгөөж бүртгэн, хүлээн зөвшөөрүүлж ажиллалаа.

Дээрх статистик мэдээнээс үзэхэд актын үнийн дүнгийн 57.9 хувь нь биелсэн дүнтэй байна.

2.4 АЙМГИЙН ИТХ-Н ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРСДИЙН САНААЧИЛГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ. Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 оны Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ИТХ-н захиалгаар Орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн явц байдал, өөрсдийн санаачилгаар хийгдэх Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүн аудитыг төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

2.4.1 Орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн явц байдал.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 02 сарын 18-ны өдрийн 28 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд 2016-2020 онд мөрдөгдөж байна.

Энэхүү бодлого нь баримтлах зарчим, удирдлагын тогтолцоо, баримтлах чиглэл, хэрэгжилтийг зохион байгуулах гэсэн чиглэлтэй байна. Бодлогын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын удирдлага, чиглэлийн дагуу Орон нутгийн өмчийн газар нь өмчийн талаар баримтлах бодлогын хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган зохион байгуулж, удирдлагаар хангах, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулахаар зааж, биелэлтийг жил бүр аймгийн ИТХ-д тайлагнахаар заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, 77.2.2-т “ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх” гэж заасан байтал аймгийн ИТХ нь ОНӨГ-ын ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнээгүй, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах ажлыг зохион байгуулаагүй байна.

Нийт 546.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 39.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаж орон нутгийн төсөвт 72.3 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Дуудлага худалдаагаар зарагдах боломжгүй 23 авто тээврийн хэрэгслийг хаягдал гэж үзсэн бөгөөд тэдгээрээс 2.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 2 авто тээврийн хэрэгсэл тухайн байгууллагад сэлбэгээр ашиглагдаж байгаа ба 2 авто тээврийн хэрэгслийн хаягдлын үнийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Иймд 2 авто тээврийн хэрэгслийн үнийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 онд ОНӨГ нь хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах сарын аян зохион байгуулан, хөрөнгийг кодтой болгон, зурагжуулах ажил зохион байгуулсан боловч аудитын явцад тулган баталгаажуулалт хийхэд тухайн үеэс хойш шинэчлээгүй, тооллого хийсэн эсэх нь тодорхойгүй, хөрөнгө эзэмшигчийн картыг шинэчлээгүй зэрэг зөрчлүүд байсаар байна. Аудитын явцад 44 байгууллагын хөрөнгийг тулган баталгаажуулахад 18 байгууллага зөрчилтэй байсан тул залруулах талаар заавар, зөвлөмж өгч ажиллалаа. 6 байгууллага 125670.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн эд хариуцагчийн карт, бүртгэлийг шинэчилсэн бол 12 байгууллага 46048.8 төгрөгийн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг залруулаагүй тул ОНӨГ-т хариуцуулан албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв

Аудитаар нийт 2924.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 8.6 сая төгрөгийн 1 акт, 2915.8 зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүллээ.

2.4.2 Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудит.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 30-ны 12/04 дүгээр тогтоолоор 2019 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар 261 төсөл, арга хэмжээ, 170 төсөл, хөтөлбөр, нийт 431 төсөл, арга хэмжээнд 28140.7 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 45 төсөл, арга хэмжээнд 1455.5 сая төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр 9 төсөл, арга хэмжээнд 801.0 сая төгрөг тус тус баталсан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын задаргаа	ТАХ-ний тоо	Батлагдсан мөнгөн дүн
1	Шинээр хийгдэх хөрөнгө оруулалт	148	19,190.3
2	Шилжих үлдэгдлээр	115	2,969.2
3	Байгаль хамгаалах арга хэмжээ	45	1,455.5
4	Авто замын сан	9	801.0
5	Төсөл хөтөлбөр	170	5,981.2
6	Нийт	487	30,397.2

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

- Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2019 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцээгүй 244.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг баталжээ.
- Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүйгээс зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагджээ.
- Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж байгаа ч чанар, байдлын хувьд зөрчил гарсаар байна.
- Захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, гэрээг үнэн зөв дүгнэх шаардлагатай байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 онд хүрэх зорилтот түвшин өмнөх оноос буурсан байна.

Аудитаар нийт 219.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.8 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 25.7 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүллээ.

2.4.3 Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүн.

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 30-ны 12/04 дүгээр тогтоолоор 2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр 207 төсөл, хөтөлбөрт 7188.4 сая төгрөг, баталсан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байдлаар харуулбал:

Хүснэгт 1		/сая төгрөг/	
№	Төсөл, хөтөлбөрийн задаргаа	Төсөл, хөтөлбөрийн тоо	Батлагдсан мөнгөн дүн
1	Хөрөнгө оруулалтын зардлаас	170	5,981.2
2	Байгаль хамгаалах арга хэмжээ	32	896.6
3	Эрдэнэт сан	5	310.6
4	Нийт	207	7,188.4

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсөл, хөтөлбөрийг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байна.
- Үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаатай арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.
- Захиалагчийн хяналт хангалтгүйгээс баримтын бүрдэл хангагдаагүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд үүссэн байна.
- Төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж, үр дүнг нарийвчлан тооцоогүй байна.

Аудитаар нийт 1750.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 473.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1277.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлжээ.

2.5 АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛТАЙ ХАРИЛЦСАН БАЙДАЛ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын дагуу төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 16-р хуралдаанд танилцуулсан.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэсэн заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд төсвийн үр ашгийг дээшлүүлэх, 2398.3 сая төгрөгөөр зардал бууруулах, орон нутгийн төсвийн орлогыг 1962.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой дүгнэлтийг хүргүүлж танилцуулсан.

2021 онд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөний төслийг УАГ-т хүргүүлсэн ба 2020 онд ИТХ-ын захиалгаар "Орон нутгийн



өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн явц байдал” гүйцэтгэлийн аудитыг хийж аудитын тайланг хүргүүлсэн.

3-Р БҮЛЭГ

СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

3.1 СУРГАЛТ

ҮАГ-ын ажилтан, албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрийн мэргэжлийн мэдлэг, дадлагыг нэмэгдүүлэхийн тулд “Сургалт хөгжлийн стратеги 2018-2022” төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд үүний дагуу аудиторуудаас авсан санал хүсэлт, судалгааг үндэслэн Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны “Мэргэшлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө” боловсруулан батлуулж, мөрдөн ажиллалаа.

Шинээр батлагдсан Төрийн аудитын тухай хууль болон МУЕА-ын тушаалаар 2020 онд шинээр батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан хаагчид илүү цагийн нэмэгдэл хөлс олгох журам", "Улс төрийн нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргахад мэдээллийг нууцлах, хамгаалах журам", "Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам", "Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам", "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал", МУЕА-н 2020 оны А/76, түүнтэй холбогдуулан СУГ-аас ирсэн чиглэлийг тус тус уншиж судлан, ажилдаа хэрэгжүүлж байна.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу Оюун-Ухааны шүр Институтээс зохион байгуулсан "Байгууллагын ажилтны манлайлал" сэдвийн хүрээнд 16 цагийн сургалтад бүх албан хаагчдыг хамруулсан.

ТАБ-ын 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдыг дотоод гадаадын мэргэшүүлэх сургалтад “Covid-19” вирустэй холбоотойгоор хамруулаагүй байна.

Аудитын байгууллагын удирдах ажилтны семинарт Тэргүүлэх аудитор оролцож, ТАБ-ын алсын хараа, эрхэм зорилго, 2019 оны ажлын тайлан, 2019-2024 оны стратеги төлөвлөгөө, ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үндсэн зорилт, цахим хөгжил, дижитал аудит зэрэг олон сэдвээр сургалт мэдээлэл авч, анхаарах гол асуудлуудаар үүрэг чиглэл авч ажиллаа. Сургалт зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг бүх ажилтнуудад танилцуулан, дотоод сургалт зохион байгуулсан.

Удирдлагын академиас зохион байгуулсан ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтныг мэргэшүүлэх багц сургалтад 2020 оны 4 сард ахлах аудитор Г.Оргилмөрөн, Жавзмаа нар хамрагдсан.

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчийн Институтээс зохион байгуулсан 14 хоногийн аудиторын эрх олгох онлайн сургалтад 7 ажилтныг хамруулан шалгалт өгч тэнцсэн, аудиторын батламж авах болзол хангасан 4 аудитор батламж авсан, 3 аудитор мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхээ аваагүй байгаа тул олгогдоогүй байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах онлайн сургалтад 2020 оны 09 дүгээр сарын 21-ээс 10-р сарын 12 хүртэл Тэргүүлэх аудитор, аудитор Т.Болормаа нар хамрагдаж 10 дугаар сарын 14-нд шалгалт өгч эрхээ сунгуулсан, аудитор О.Гантуяа мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн сургалтад 10-р сарын 22-оос 11-р сарын 4-ны хооронд хамрагдаж хугацаагүй эрхээ авсан.

Монгол Улсын Сангийн Яам, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Сангийн яамнаас зохион байгуулсан Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын мэдлэгийг дээшлүүлэх 12 цагийн сургалтад санхүүгийн аудитын багын ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Т.Болормаа, аудитор О.Гантуяа, нягтлан бодогч Ж.Наранчимэг нар хамрагдсан.

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 2020 оноос төрийн аудитын байгууллагын сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Төрийн аудитын байгууллагын нийт албан хаагчдад сургалт, хөгжлийн шинэ системээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу бэлтгэсэн “Хуулийн хэрэглээ” хичээлийн цахим сургалтыг зохион байгуулах талаарх онлайн хуралд 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр бүх албан хаагчид хамрагдсан. Аудитын сургалт, хөгжлийн системд аудиторууд нэвтэрч цахим сургалтын үйл ажиллагаанд бүрэн хамрагдаж, системийн нэмэлт цэсэд тавигдсан хичээлүүдийг судалж, 1, 2-р явцын сорил шалгалтыг амжилттай өгсөн. Сургалтад сууж, олж мэдсэн арга туршлага, мэдээ мэдээллийг цаг алдалгүй бусад ажилтан албан хаагчдад хүргэж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, ажилтны мэдлэг, ур чадварыг байнга хөгжүүлэх, нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ:

Байгууллагын Orkhon.audit.mn цахим хуудаст аудитын тайлан, байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын албаны тайлант онд хийсэн аудитын талаарх товч мэдээллийг байршуулж, мэдээллийн санг тогтмол шинэчлэн ажиллалаа. Orkhon@audit.gov.mn цахим хаягаар 142 цахим шуудан хүлээн авч, 148 цахим шуудан илгээж, audit.mn вэб сайтад санхүүгийн тайлангийн 73 ТШЗ-ийн аудитын тайлан, ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан, аймаг, сумын ИТХ-ын сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журмыг байршуулаад байна. Мөн аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцох 8 намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, мөрийн хөтөлбөрийн дүгнэлт, хандивын тайлан, хандивын тайлангийн дүгнэлтийг, бие даан нэр дэвшихээр мөрийн хөтөлбөр ирүүлсэн 75 хүний мөрийн хөтөлбөр болон мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн мэдээллийг байгууллагын шинэчилсэн цахим хуудсанд дахин мэдээлэв.

Сервер, сүлжээний төхөөрөмж, дагалдах хэрэгслийн тасралтгүй хэвийн ажиллагааг тасалдал гарсан тухай бүр төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг, шалгаж тестэлж, УАГ-ын мэдээлэл, технологийн ажилтнууд, орон нутаг дахь “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн инженертэй холбогдож шалтгааныг тогтоон, хэвийн ажиллагааг хангаж байна. Тайлант онд нийт 11 удаагийн online хуралд компьютер, тоног төхөөрөмжийн бэлэн



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

байдлыг хангаж оролцож, Covid-19 вирусийн эсрэг арга хэмжээ авч буй цаг үед хүссэн газраасаа онлайн хуралд оролцох боломжийг бүрдүүлсэн Zoom программыг гар утас болон компьютер дээр суулгаж, мөн ҮАГ-аас Microsoft teams программд албан хаагчид бүртгүүлж зайнаас ажиллах боломжийг бүрдүүлсэн байна. Байгууллагын интернэт сүлжээний хүлээн авагч төхөөрөмжийг сольж Fortinet төхөөрөмж тавьсан.

Байгууллагад ашиглагдаж буй компьютерүүд нь Windows 7 pro болон Windows 10 pro үйлдлийн системтэй, хэрэглэгчдийн нууц үгээр хамгаалагдсан. Шинээр хүлээн авсан 6 процессорын холбогдох тохиргоо хийж, вирусийн программ суулгаж, хэрэгцээтэй файлуудыг шилжүүлэн хуулж, хүн тус бүрд хүлээлгэн өгч, хуучин хэрэглэж байсан процессоруудыг хүлээн авч, архивыг цэвэрлэн гэрээт аудиторуд ажиллуулав. Бүх албан хаагчдын компьютерт суулгасан байсан Kaspersky Network Agent, Kaspersky Endpoint Security вирусийн программыг ESET endpoint antivirus болох лицензтэй вирусийн программаар сольж суулгасан. Зөв бичгийн болор дуран программын 8 лицензийг аудиторудын компьютерт суулгаж идэвхжүүлэн ашиглаж байна. СТА-н багт шинээр томилогдсон аудиторын ашиглах компьютерыг форматалж холбогдох программыг бүрэн суулгаж, сүлжээнд суулгаж ашиглалтад өглөө. ҮАГ болон Орхон аймгийн Тагнуулын газраас ирүүлсэн компьютер, тоног төхөөрөмж, интернэт сүлжээ, хэрэглээ, аюулгүй байдалтай холбоотой судалгааг хүргүүлж Windows 10 үйлдлийн системтэй 7 албан хаагчийн компьютерыг нэгдсэн домэйн удирдлагын системд холболоо.

4-Р БҮЛЭГ

ДОТООД АЖИЛ

4.1 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Төрийн албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу байгууллагын удирдлагын үйл ажиллагааг стандартын дагуу зөв баримтжуулах, баримт бичгийг мэдээлэл, тоо бүртгэлийн санд оруулах, албан баримт бичгийг шуурхай хянан шийдвэрлүүлэх, үүссэн баримт бичгийг зөв ангилж төрөлжүүлэх, баримт бичгийн эмх цэгц, бүрдлийг сайжруулах, нууцлах, хадгалах, хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2020 оны 12 дугаар сарын 15-ний байдлаар нийт 408 бичиг ирсэн, 2019 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх хүсэлт 112, зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт 65, ҮАГ-с 18, мэдээлэл хүргүүлэх тухай 34, бусад 197 бичиг ирсэн ба 100 хувь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна. Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн байдлаар нийтдээ 410 албан бичиг явсан бөгөөд үүнээс 41 бичиг нь ҮАГ-т, баримт ирүүлэх тухай 33, Аудитын гэрчилгээ 102, албан тоот 234 байгууллагад хүргүүлэн ажиллаа.

Архивын хууль тогтоомжийн дагуу баримт, хадгаламжийн нэгжийг заасан хугацаанд ажилтнуудаас хүлээн авч, архивлах, байнга хадгалах баримтуудыг аймгийн архивд шилжүүлэх, хадгалалтын хугацаа нь дууссан зарим баримтыг устгах арга хэмжээ авч ажиллах, архивын нэгжийн ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд 2020 оны 12-р сарын 15-ны байдлаар 2015 оны 85 баримт, 2016 оны 88, 2017 оны 85 баримт, 2020 оны 124 баримт, нийт 382 баримтыг стандартын дагуу товьёг, баталгааны хуудсыг бичиж,



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

үдэж, нүүрлэн бэлтгэж, нягтруулсан шүүгээнд хайрцаглан, дугаарлаж, хадгаламжийн нэгж үүсгэсэн.

Архивын үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийг түргэн шуурхай ашиглах, хэрэглэх зорилт тавин 2020 оны 70 хадгаламжийн нэгжийг цахим архив үүсгэн, архивлах ажил хийгдсэн.

Байгууллагаас гаргасан тушаалуудыг чиг үүргээр нь газрын үйл ажиллагаатай холбоотой А тушаал, хүний нөөцийн чиглэлээр Б тушаалаар ангилан, 2020 онд нийтдээ 42 тушаал гарч, үүнээс байгууллагын үйл ажиллагаа, дотоод ажилтай холбоотой А тушаал 27, хүний нөөц боловсон хүчинтэй холбоотой Б тушаал 15 гарсан байна.

Дотоод удирдлагын Эйбл сүлжээгээр ирүүлсэн “Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-ын төсөлд 11 санал, “Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам”-ын төсөлд 14 санал тус тус хүргүүлсэн. Нийцлийн аудитын газраас боловсруулсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд “Улс төрийн нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргахад мэдээллийг нууцлах, хамгаалах журам ”-ын төсөл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал”, “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах”, “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх”, “Төрийн аудитын байгууллагаас шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журмын төсөл, “Захиргааны ерөнхий хуулийн төсөл”, “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төсөл, Монгол Улсын жилийн төсвийн төсөлд дүгнэлт гаргах ажлын заавар, төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төсөл боловсруулах болон хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах талаар санал боловсруулах ажлын хэсэгтүүдэд санал хүргүүлж ажиллаа.

4.2 АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, 2019 оны ажилтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд 8 ажилтан гаргаж, тайланг 2020 оны 02 сарын 20-нд хэвлэж баталгаажуулан, Төрийн болон албаны нууцын баталгааг нийт ажилтнуудаар гаргуулсан.

Авлигатай Тэмцэх газрын даргын 2018 оны 121-р тушаалаар батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам"-д заасныг баримтлан аудиторуудын ХАСХОМ, баталгааны маягт, бүртгэлийн дэвтэр, тайлан мэдээг архивд шилжүүлэн мэдээллийн нууцлалыг ханган ажиллаж байна.

Гүйцэтгэж буй аудиттай холбоотой, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай 120 мэдэгдэл гаргасан. Нийт албан хаагчдад шуурхай хуралдаанаар ёс зүйтэй холбоотой үүрэг даалгавар удаа дараа өгөгдөж /дүрмийн 1.4, 4.1, 4.2.1, 4.2.5, 4.2.8, 4.2.9, 4.2.15, 4.2.16 зэрэг заалтуудыг уншиж, дахин сануулсан/, Байгууллагын дотоод журам, Ёс зүйн дүрэм, Албан тушаалын тодорхойлолтыг дахин танилцуулж, уншуулан, гарын үсгээр



баталгаажуулсан. Шинээр томилогдсон ажилтны ХАСУМ-ын баталгааны хуудсыг бүртгэж, ҮАГ-т цахимаар хүргүүлсэн.

4.3 БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВ САНХҮҮ

2020 онд улсын төсвөөс 476.4 сая төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллаа. Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 338.6 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 50.4 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 6.9 сая төгрөг, урсгал засварын зардалд 0.2 сая төгрөг, албан томилолтын зардалд 3.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 20.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.4 сая төгрөг, нийт 426.4 сая төгрөг зарцуулсан.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны 6-р сарын 22-ний өдрийн 205 дугаар албан бичгээр байгууллагын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж хүргүүлээд байна.

Шилэн дансны мэдээллийн самбараар байгууллагын чиг үүрэг, тухайн жилийн батлагдсан төсөв болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, холбогдох хууль эрх зүй, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээлэл, аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, шилэн дансны цаг үеийн мэдээлэл, бусад мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь тогтмол мэдээлж, shilendans.gov.mn, audit.mn цахим хуудсанд 2020 онд 141 мэдээлэл байршуулахаас бүрэн байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, ҮАГ-аас ирүүлсэн мэдээ, судалгааг цаг тухай бүрд гарган ҮАГ-ын Тамгын газарт хүргүүлж ажилласан. Мөн ХХООАТ-ын 2019 оны жилийн эцсийн тайлан, НД-ын 2020 оны 1-12 сарын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулан, НДШ-д 76,1 сая төгрөг, ХХООАТ-д 29,0 сая төгрөг тооцоо хийж, өглөг авлагагүй ажиллаа.

Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2021 оны төсвийн төслийг, Төрийн аудитын хуулийн шинэчлэлтэй холбоотой, МУЕА-ын 2021 оны төсвийн төсөл боловсруулах ажлын хүрээнд, ТАБ-ын хэмжээнд нэгдсэн бодлого, арга аргачлалаар нэгтгэх болсонтой холбоотой plan.unicus.mn программаар төсвийн төслийг хийж 2020 оны 4-р сарын 30-нд хүргүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 1-р сарын 28-ний өдрийн А-1/131, 10-р сарын 05-ний өдрийн А/1705 дугаар албан бичгийн дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 15 нэрийн нийт 13474.6 мянган төгрөгийн хөрөнгийг актлан, данснаас хасаж, ҮАГ-т 3-р сарын 30-ний өдрийн 134, 12-р сарын 15-ны 415 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

2020 оны 6-р сарын 23-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулагдсан тооллогын комисс 2020.06.25-26-ний өдрийн хооронд байгууллагын хагас жилийн хөрөнгийн тооллого хийж үр дүнг ҮАГ-т хүргүүлсэн.

Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, Хүний нөөцийн албанд албан хаагчдын цалингийн болон нийгмийн аж байдлын судалгаа гаргаж хүргүүлэн, албан хаагчдын цалингийн бүх тооцоолол, нэмэгдлүүдийг хянан, орон тоо, цалин хөлс нэмэгдэл, суутгал, аюулгүй байдал, нууцлал бүхий Төрийн албаны цалингийн нэгдсэн системд хамрагдсан.

4.4 ХАМТ ОЛНЫ ЭВ НЭГДЭЛ, НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭ



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Байгууллага хамт олныхоо эв нэгдэл, хамтын ажиллагааг дэмжих, ёс зүйг эрхэмлэсэн зөв албан хаагчийг төлөвшүүлж, зөв үр дүнд хүрэх зорилт тавин ажиллаа.

Байгууллагын эцэг эхийн зөвлөл, Нийгмийн асуудал эрүүл ахуйн хариуцсан комиссоос дараах асуудлуудыг хариуцан шийдвэрлүүлсэн байна. Үүнд: Шинээр хүүхэдтай болсон 2 албан хаагчид буцалтгүй тусламж, эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилчдын 21 хүүхдэд бэлэг дурсгалын зүйл, Монголын цагаан сар, Ахмадын баярыг тохиолдуулан 11 ахмадад хүндэтгэл үзүүлж, тусламж дэмлжэг, ердийн галладаг зуухтай гэр хороололд амьдардаг 1 жаилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн. Байгууллагын нийт албан хаагчид 2020 оны 05 сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хот, “Гранд мед” эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан.

Улсын онцгой комисс, аймгийн онцгой комисс, бусад байгууллагаас ирүүлсэн заавар, зөвлөмж, ҮАГ-аас Коронавирус /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх 11 удаагийн зөвлөмж, мэдээлэл, зөвлөлгөөг хэрэгжүүлэн, “Covid-19” вирусээс урьдчилан сэргийлж ажлын байрны ариутгалыг 6 удаа хийлгэн, 2600 ш амны хаалт, 21 ширхэг ариутгалын бодис худалдан авч албан хаагчдад олгосон. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, дархлааг нэмэгдүүлэх зорилгоор бүх алба хаагчдад витамин Д, витамин С, 99.9% Алоэ жүүс авч олгосон. Мөн Төрийн аудитын байгууллагын коронавирүсээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулж 140.0 мянган төгрөгийн хандив цуглуулж хүргүүлсэн. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг ажилласанд тооцож олгох чиглэл баримтлан 0-12 насны хүүхэдтэй 4 ажилтныг хорогдуулсан цагаар ажиллуулж, шаардлагатай тохиолдолд гэрээсээ ажлаа гүйцэтгэх арга хэмжээг авч ажиллаа. Ажлын байран дээр хийж болох 8 энгийн дасгалыг 2 дугаар сараас хийж хэвшүүлээд байна.

Байгууллагын нийт албан хаагчид 2020 оны 05 сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хот, “Гранд мед” эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан.

2020 оны 10-р сард зохион байгуулагдсан нутгийн удирдлагын ордны аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд тэргүүн байр, олс таталтын тэмцээнд 3-р байр эзэлсэн.





4.5 ШИНЭЭР САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Төрийн аудитын үндсэн зарчим бол ил тод, бодитой байх явдал юм. Бид 2021 оны Аудитын төлөвлөгөөгөө иргэдийн оролцоотой боловсруулах зорилт тавин ил тод, нээлттэй болгох, иргэдэд ойртуулах, иргэдийг оролцуулж Аудитын төлөвлөгөөгөө боловсруулахыг зорьж “Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны аудитын төлөвлөгөөг иргэдийн оролцоотой хийх нь” судалгааны ажлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академитай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаа. Иргэдийн санаа бодлыг сонсож, иргэдийн оролцоотой Аудитын төлөвлөгөө боловсруулахын тулд иргэдэд Төрийн аудитын үйл ажиллагааны талаар тодорхой хэмжээний хялбаршуулсан мэдээлэл өгөх, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг эерэгээр иргэд, олон нийтэд таниулах хэрэгтэй гэж үзээд, мэдээллийг боловсруулан, асуулгын хуудсаар иргэдээс судалгаа авч боловсруулсан. COVID-19 тархаж хөл хорио тогтоогоогүй бол иргэдтэй уулзаж, тэдэнтэй тулж ажиллаж, илүү нарийн мэдээлэл авч болох байлаа. Харамсалтай нь нөхцөл байдал бидэнд тийм боломж олгосонгүй. Гэхдээ бид байгаа боломжоороо энэ судалгааг хийж мэргэжлийн судлаачидтай хамтран тайлангаа бичлээ. Энэхүү санаачилга нь төр иргэний хоорондын харилцааг бэхжүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнийг Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (INTOSAI-International Organization of Supreme Audit Institutions)-ын баримт бичгүүдэд тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт (ISSAI-The International Standards of Supreme Audit Institutions)-ын 12-т тодорхой зааж өгсөн байна. Энэ баримт бичгийн оршил хэсэгт “Төрийн санхүүгийн хяналтыг хэрэгжүүлдэг Төрийн аудитын дээд байгууллага нь иргэдийн амьдралд өөрчлөлт авчрах чухал хүчин зүйл юм. Төрийн байгууллагуудын болон улсын салбарын байгууллагуудын хөрөнгө нөөцийг зөв зарцуулж байна уу гэдэгт хяналт тавьж манаж байдаг байгууллага бол Төрийн аудитын байгууллага бөгөөд энэ нь нийгэмд итгэл бий болгож эерэг нөлөө үзүүлдэг” гэсэн санааг хэлсэн байна (утгачлан орчуулсан Ш.Б.). Төрийн аудитын байгууллага энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд төлөөллийн байгууллагууд болон иргэдтэй ойр байж, тэдэнтэй хамтарч ажиллах, тэдэнд үйл ажиллагаагаа тайлагнах, ил тод нээлттэй байлгах явдал юм.

Төрийн аудитад иргэдийн оролцоог хангах судалгааны ажил бүрэн хийгдэж, 7 дүгнэлт, 5 зөвлөмж бүхийн судалгааны тайланг хүлээн авсан. Үүнд:

Нэг. Судалгааны ажил нь Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн санал, бодлыг тусгах чиглэлээр Орхон аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас гаргасан шинэ санаачилга төдийгүй тус салбарын мэдээллийг олон нийтэд хүргэх, тодорхой асуудлын хүрээнд иргэдийн санал, бодлыг судалж, түүнийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөндөө тусгах чиглэлээр хэрэгжүүлсэн үр дүнтэй ажил болж чадлаа.

Хоёр. Уг судалгаанд зөвхөн Орхон аймгийн өрх, иргэдийн төлөөллийг хамруулан мэдээлэл цуглуулсан бөгөөд аймгийн нийт 29.0 мянган өрхийн статистик, аймгийн хүн ам зүйн статистик үзүүлэлтүүд, холбогдох бусад мэдээлэлд тулгуурлан аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 25 багийн баг тус бүрийн нийт өрхийн 1.5 хувийг түүвэрлэн судалгаанд хамруулж, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгсөн нь аймгийн нийт өрх болон иргэдийн төлөөлөл зохих түвшинд холбогдох мэдээллээр хангагдсан болохыг илэрхийлж байгаа юм. Судалгааны ажил нь Төрийн аудитын байгууллага, түүний хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд хүргэх талаасаа ч, Орхон аймаг дахь Төрийн аудитын газар 2021 оны үйл

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ажиллагааны төлөвлөгөөндөө иргэдийнхээ санал бодлыг судлан, тусгах талаасаа ч чухал ач холбогдолтой ажил болсон.

Гурав. Судалгаанд зөвхөн аймгийн нийт өрхийн төлөөлөл оролцоод зогсохгүй, тухайн аймгийн нийт хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүд болох нийт хүн амын нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлт зэрэг үзүүлэлтүүдийн төлөөлөл бүрэн хангагдсан нь тухайн судалгаанд хамрагдсан иргэдийн санал, бодолд тулгуурласан судалгааны үр дүнг аймгийн нийт иргэдийг төлөөлүүлэх боломжтойг илэрхийлж байгаа юм.

Дөрөв. Мэдээллийн хүртээмжийн хувьд Төрийн аудитын үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдлэг, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, тус үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй байдаг эсэхийг судалгаанд оролцогчдоор үнэлүүлэхэд тэдний үнэлгээнд дунд зэрэг болон хангалтгүй гэсэн үнэлгээ давамгайлж байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн 20.0-22.6 хувь нь энэ талаар мэдэхгүй, 17.7-31.3 хувь хангалтгүй, 32.5-43.6 хувь нь дунд зэрэг, 11.5-15.8 хувь нь сайн, 1.2-2.8 хувь нь маш сайн гэж хариулсан байна. Дээр нь нийт судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь энэ талаар мэдээлэл дутмаг, энэ талын мэдээллийг хаанаас авахаа мэддэггүй, мэдээлэл огт авч чаддаггүй гэж хариулсан байгаа нь Төрийн аудитын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд хэрэгцээтэй үедээ авч чадахгүй байгааг илэрхийлж байна. Мөн иргэд Төрийн аудитын үйл ажиллагааны талаарх мэдээлэл олж авдаг гол эх сурвалж нь *нэгдүгээрт*, телевиз, *хоёрдугаарт*, фэйсбүүк, *гуравдугаарт*, найз нөхөд, ойр дотны хүмүүс, төрийн байгууллага, мэргэжилтнүүд гэж үзсэн байна.

Тав. Төрийн аудитын талаарх ойлголт, төсөөллийн хувьд: Судалгааны үр дүнгээс үзэхэд иргэдийн дийлэнх нь Төрийн аудитын үйл ажиллагааны талаарх өөрсдийн ойлголт, мэдлэгээ дунд зэрэг гэж үнэлсэн байна. Гэсэн хэдий ч тэд Орхон аймаг дахь Төрийн аудитын газар 2021 онд аудитын үндсэн төрлүүдээс санхүүгийн аудитыг түлхүү хийх шаардлагатай, дээр нь иргэдийн хүсэлт, санаачилгаар хийх аудитыг ихээхэн чухалчилах хэрэгтэй гэсэн хариултыг өгсөн байна.

Зургаа. Иргэдийн санал, бодлын тухайд: Энэ хэсэгт Орхон аймгийн иргэд 2021 онд Төрийн аудитын байгууллагаас ямар сэдвээр, ямар төрлийн аудит хийлгэж, хариулт авахыг хүсч буйг судалж, нэгтгэн дүгнэсэн болно. Тухайлбал, 2021 онд Орхон аймгийн иргэд эрүүл мэнд, авто зам, эрчим хүч, хөдөлмөр эрхлэлтийн салбарын үйл ажиллагаа, төсөв, хөрөнгө оруулалтад аудит хийх шаардлагатай гэж үзсэн байна. Мөн цаашид Төрийн аудитын газраас гүйцэтгэх төрийн аудитын үйл ажиллагаанд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц, нөөц сан, аймаг, сумын ИТХ, түүний ажлын алба, ЗДТГ, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэгч компаниуд, аймаг, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёл, спортын байгууллагуудын төсвийн захирагч, байгууллагыг түлхүү анхаарч аудит хийх шаардлагатай гэжээ. Иргэд аудитын төрлүүдээс 2021 онд санхүүгийн аудит болон гүйцэтгэлийн аудитыг улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллагууд, төслийн нэгж, тусгай сангууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч компаниудад хийх нь чухал гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 80-90 хувь нь 2021 онд аудит хийх шаардлагатай гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл 87.9 хувь нь аудит хийх шаардлагатай, 12.1 хувь нь аудит хийх шаардлагагүй гэж үзжээ. Төрийн аудитын байгууллага, түүний үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэл иргэдийн дунд дутмаг байгаагаас тус байгууллагын үйл ажиллагааг үнэлж, цаашид сайжруулах талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахгүй байгааг асуулгын судалгааны үр дүн илтгэсэн болно.

Долоо. Энэ судалгааг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ажилтнууд судлаачдын заавар, зөвлөмжийн дагуу аймгийн нийт багийн нийгмийн ажилтнуудыг оролцуулан зохион байгуулсан учраас цаашдаа ийм төрлийн судалгааг өөрсдөө авах

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

тодорхой хэмжээний дадлага туршлага хуримтлуулсан. Цаашдаа Төрийн аудитын үйл ажиллагааг иргэдэд танилцуулах, ялангуяа тэдний санаа бодлыг тусгаж төлөвлөсөн ажлаа тайлагнах явцдаа дараа жилийнхээ төлөвлөгөөнд тусгах саналаа авч хэвших боломжтой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;” гэж, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Монгол улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.” гэж Төрийн аудитын байгууллага Үндсэн хуулийн байгууллага болж, Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга Монгол Улсын Их Хурлаар батлагдсанаар, 2020 онд ТАБ-ын хэмжээнд Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчины шинэтгэлийн жил болох зорилт бүрэн хангагдсан жил болж өнгөрлөө.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнөөс гаргасан ТАБ-ын хэмжээнд “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгох зорилт дэвшүүлснийг удирдлага болгон, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 бүлэг 62 арга хэмжээ, өмнөө тавьсан зорилтоо бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

“Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны аудитын төлөвлөгөөг иргэдийн оролцоотой хийх нь” судалгааны ажлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн эрдэмтэн доктор, мэргэжлийн судлаачидтай хамтран гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын үр дүнгээр Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд эерэгээр таниулан, аудитад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний санаа бодлыг сонссон жил боллоо.

2020 онд 64.9 сая төгрөгийн актын биелэлтийг хангуулан, орон нутгийн төсөвт оруулж, 1990.5 сая төгрөгийн албан шаардлага, 8698.4 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг тус тус хангуулан, 14708.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжтэй буюу 426.4 сая төгрөгийн төсвийг зарцуулж, төсвийн 1 төгрөгт 34.5 төгрөгийн аудитын үр өгөөжтэй ажиллаа.